



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2016 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/108


Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дүгээр зүйлийн 47.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Хөрөнгө гаргах тухай 2016 оны А/627 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн “Хөрөнгө гаргах тухай” А/627 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан инженерийн шугам сүлжээ, дээврийн засвар шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Өвөлжилтийн болон хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажилтай холбогдуулж хөрөнгө оруулалтын ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж зөвлөмжийг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэхийг Үнэлгээний хороо /Э.Энхцэцэг/-нд үүрэг болгосугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД  
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧИ  Т.ГАНТӨМӨР

УХА0501 9077367

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2016 оны *дугаар* сарын *дунд* өдрийн  
*дугаар*.....тушаалын хавсралт



## ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭДДЭХҮҮН

Үнэлгээний хорооны дарга:	Э.Энхцэцэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, Санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд:	Э.Уянга	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, Санхүүгийн хэлтсийн хуулийн мэргэжилтэн
	Р.Даваасүрэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
Иргэн	Б.Баярчимэг	Баянгол дүүргийн 19-р хороо, 57 дугаар байр 82 тоот
Нарийн бичгийн дарга	О.Батмөнх	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн